



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 527

Улаанбаатар хот

Г Банк бус санхүүгийн байгууллагаас олгох  
финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын  
харьцаа тогтоох тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Банк бус санхүүгийн байгууллагаас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцааг 70 хувиас хэтрүүлэхгүй байхаар тогтоосугай.

2.Банк бус санхүүгийн байгууллагаас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцааг тооцохдоо Монголбанкнаас баталсан “Өр, орлогын харьцааг тооцох аргачлал”-ыг мөрдсүгэй.

3.Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдүүлэхээр тогтоосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.САЯРСАЙХАН

151800001100